

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ

Г. Сүхбаатар

Монгол улс нутгийнхаа хэмжээгээр Англи, Франц мэтийн их гүрнээс том боловч хүн амын тоогоор тэдгээрээс олон арав дахин цөөн учир хүн амынхаа тоотой шүтэлцсэн захиргаа, эдийн засаг, соёлын байгууллагын хэмжээгээр бага болохоор жижиг орны тоонд ордог байна.

Монгол улс түүхэн хөгжил, нутгийн байгаль-цаг уурын нөхцөл, байгалийн унаган төрхийг хадгалсан байдал, газарзүйн байршил, аж ахуй, соёл, хүн амын онцлог зэргээрээ өвөрмөц жижиг оронд тооцогдоно.

Монголчууд 2200 гаруй жилийн төрийн уламжлалтай эртний ард түмэн юм. Манай ард түмэн түүхэн хөгжлийн мандал, буурлын маш ээдрээтэй замыг туулсан боловч төрийн уламжлал, үндэсний соёлоо хадгалан хөгжүүлж нүүдлийн сонгодог мал аж ахуйгаа эдийн засгийн нэг чухал салбар болгон эрхэлсээр байна.

МЭӨ 209 онд одоогийн Монгол улсын нутгаар төвлөн байгуулагдсан Хүннү улс (МЭӨ 209-МЭ 2-р зуун) захиргаа-цэргийн аравтын зохион байгуулалттай, нүүдлийн сонгодог мал аж ахуйг аж ахуйн гол салбар болгосон түрүү феодалын улс байсан юм. Бурханы шашин Хүннү улсын үед хаан угсааныхны дотор нэвтэрч эхлэн, монголын төр ёсны уламжлалын хааны засгийн үзэл суртлын үндэс болжээ. Хүннү нар нэгэн зүйл бичигтэй, нүүдэлчдийн өвөрмөц соёлтой. Монголчуудын дууны урлагийн өвөрмөц махбодь болох уртын дуу үүссэн тухай домог Хүннү улсын үеэс улбаатай байна.

Хүннү улсын шаньюй (хаан) Маодунь МЭӨ 200 онд Хятадын Хан улсын хаан Лю Банг Пинчэн (одоогийн Датун) хотын орчим дөрвөн зүсэм нийлүүлсэн 400000 морьт цэргээр бүслэж байгаад, тусгай болзол тавин, бүслэлтээс гарган явуулжээ. Ингээд Хан улс МЭӨ 198 онд Хүннү улстай байгуулсан гэрээ ёсоор Хан улс, Хүннү улс хоёр бие биенээ мөр зэрэгцэх хөрш улсууд мөн гэж зөвшөөрөн хүлээгээд хоёр улсын хилийг хятадын Цагаан хэрмээр тогтоосон билээ.

Хүннү улсыг залган байгуулагдсан Сүмбэ улс (2—4-р зуун), Монгол-Нирун улс (330 орчим-555)-аас хойш монголын төр олон зуун жилийн доройтолд оржээ. Монгол-Нирун улс 555 онд Алтайн чанад байсан эртний түрэгчүүдэд цохигдон мөхөж, үндсэн хүн амын ихэнх хэсэг нь одоогийн Монгол улсын нутгийн баруун, төв хэсгээс хөөгдөн нутгийн зүүн талын хэсэг, мөн хил зэргэлдээ нутагт 30 татар, Татар улс, Хамаг Монгол улс мэтийн нэрээр жижиг хаант улс болон хэдэн зуун жилийн турш оршин тогтнохдоо аажмаар хүчээ авсаар байжээ. Ингээд 1206 онд Их Монгол улс байгуулагдан дэлхийн түүхийн тавцан дээр дахин гарч мандлаа. Гэвч Хубилай 1260 онд Их Монгол улсын хаан ширээг булаан авч монголын уламжлалт төр ёсыг гажуудуулж 1217 онд Хятадад Монголын Юан улсыг байгуулан, Монгол оронд 47 жил үргэлжилсэн иргэний дайн дэгдээсний уршгаар Монгол улс хүчээ алдсаар доройтон буурах олон зуун жилийн замд орсноор барахгүй, монгол угсаатан уусан мөхөж болох аюулд нэрвэгдэж эхэлжээ. Хятадын ард түмний баатарлаг тэмцлийн үр дүнд Хятадад Монголын Юан улс 1368 онд мөхөж, Монгол улсын

төв Эх нутгаа шилжсэн нь монгол угсаатныг уусан мөхөх аюулаас аварчээ.

Монгол улс хэдэн зуун жилийн турш феодалын бутралд нэрвэгдэн бутарч доройтсон үед өндөр гэгээн Занабазарын заавраар Манж Цин улсад 1691 онд дагаар орж, төрийн тусгаар тогтнолоо алдлаа. Манжийн колоничлогчид 200 гаруй жилийн турш ноёрхохдоо засаг захиргааны хувьд Монгол орныг 80 гаруй хошуу болгон бутаргаж, шарын шашныг өөрсдийн ноёрлыг бэхжүүлэх зэвсэг болгож, монголчуудын үндэсний хувцас, үндэсний заншил, зан үйлийг гажуудуулж, монголын соёлыг гуйвуулан доройтуулж, монгол хэлийг монголчуудын хоорондын яриа, орон нутгийн захиргааны албан хэрэг хөтлөх хүрээнд явцууруулан хэрэглэх болгож, Монголын эдийн засгийг хятадын шунахай худалдаачид, мөнгө хүүлэгчдийн бүрэн эрхшээлд оруулж, монгол угсаатныг биологийн хувьд мөхлийн даваанд хүргээд байлаа.

Монголын ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний үр дүнд 1911 онд байгуулагдсан Монголын хаант улс дөнгөж 4 жил оршин тогтноод, хятадын харгис хүчний явуулгын үр дүнд 1915 онд Хятадын харьяаны автономит улс болов. Хятадын цэргийн эрхтнүүд тухайн цаг үеийн байдлыг ашиглан, цэргийн хүчээр 1919 онд Монголын автономит улсыг устган Хятадын муж болгон, хятадын цэргийн харгис дэглэмийг Монгол оронд тогтоон Монголын ард түмнийг туйлын хэрцгийгээр харгислан дарлаж байжээ.

1921 онд ялсан Монгол Ардын хувьсгалын үр дүнд БНМАУ байгуулагдан дэлхийн түүхийн тавцан дээр дахин гарч, тухайн үеийн олон улсын нэн төвөгтэй байдлын улмаас алдаж осолдсон боловч, сэргэн мандалтын замаар 70 жил хөгжсөн билээ. Одоо Монгол улс түүхэн хөгжлийнхөө хамгийн эгзэгтэй замын ацан шалаан дээр гарч ирээд байна. Монгол улсын монгол үндэстний эрүүл саруул ухаан л Монгол улсаа хөгжлийн зөв замд оруулж аварч чадах болно.

Ингэхлээр өнөөдөр Монгол улсын иргэн монголчууд давын өмнө өөрсдийгөө танин мэдэж, ойлгож, мэдэрсний үндсэнд ээр өөрсдийгөө засах нь чухал байна. Монголчууд эрүүл ухаанаараа Монгол улсынхаа үндэсний эрх ашгийг зөвөөр тодорхойлж, түүнийгээ хамгаалж чадна.

Монгол улс мэтийн жижиг орны хувьд үндэсний эрх ашгаа зөв тодорхойлох нь амин чухал ач холбогдолтой байна. Энэ эрх ашиг Монгол улсын өвөрмөц байдлаас урган гарна. «Түүхийн төгсгөл» бүтээлээрээ дэлхийн олон нийтийг шуугиулсан Френсис Фукуяма, «Улсуудын тухайлсан байнгын цогцолбор эрх ашиг бол газарзүй, гадаад хүрээллээрээ тодорхойлогддог» гэж¹ сүүлийн үеийн нэг өгүүлэлдээ дурдсан нь Монгол улсын хувьд холбогдож болмоор байна. Монгол улс умард талаасаа Оросын Холбооны улс, өмнөд талаасаа БНХАУ-аар бүрэн хүрээлэгдсэн жижиг орон юм. Энэ хүрээлэл, Монгол улсын хувьд маш чухал хүчин зүйл болно.

Монгол улсын үндэсний эрх ашгийг дор дурдсанаар хэдэн махбоднос бүрдсэн бүхэл систем гэж тодорхойлж болмоор санагдана. Үүнд:

Монгол улсын түүхийн сургамжийг тал бүрээс нь харгалзан үзэж, орчин үеийн бодит байдлын үндсэн дээр монголын ирээдүйг цогцлон байгуулж болно.

Монгол улсын үндэсний эрх ашгийг дор дурдсан зургаан махбодтой бүхэл системийн хувьд тодорхойлж болно гэж санана. Үүнд:

1. Монгол улс түүхээр заяагдсан төрийн тусгаар тогтнолоо бэхжүүлэхийн тулд хоёр их хөрш улсаас манай улсын талаар явуулж

байгаа бодлогыг тухай тухайн цаг үед зөв оношлон мэдэж, тус тусад нь тохирсон маш уян бодьтой бодлого баримтлан хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ нь товчоор хэлбэл эрүүл ухааны бодлого байгууштай. Аливаа эрүүл ухаан бол юмыг зөв танин мэдсэн мэдлэгийг үндэс болгоно.

2. Аливаа улс, орон эцсийн дүнд амьд хүмүүс мөн учир Монгол улсын монгол үндэстний экологи тус улсын үндэсний эрх ашгийн амин сүнс мөн.

Тусгаар тогтносон Монгол улсын нийгэм-улстөр, эдийн засаг, соёлын 70 гаруй жилийн хөгжлийн үр дүнд биеэ даасан нэгдмэл монгол үндэстэн бүрэлдэн тогтсон билээ. Монгол үндэстний экологи бол төрийн тусгаар тогтнол, хүн ам зүй, монгол үнэстний өвөрмөц онцлог, үндэсний соёл, монгол хэл, боловсрол, хүмүүжил гэх хэдэн махбодиос бүрдсэн бүхэл систем мөн. Бүхэл систем мөн болохоор махбодь тус бүр биеэ даасан эрэмбэ дараалсан дэд систем болон шууд, урвуу холбоосоор үйлчлэлцэж байх болно. Аль нэг махбодь нь доголдох юм бол бусад махбодид нөлөөлөн яваандаа уг бүхэл системийн шинжийг алдагдуулахад хүргэнэ. Ингэхлээр монгол үндэстний экологийн энэ цогцолбор асуулын аль нэгийг шийдвэрлэснээр бүхэл системийн асуудал дуусвар болохгүй нь тодорхой. Монгол улсын мэргэжилтэн нар сүүлийн үед хүн ам зүйн асуудлыг нэлээд анхаарч эхэлсэн (3) нь нэн сайшаалтай. Гэвч энэ нь асуудлыг шийдвэрлэж байгаа хэрэг биш зөвхөн судалж эхэлж байгаа хэрэг юм. Монгол улс сүүлийн үеийн эдийн засгийн гүнзгий хямралд орсны уршгаар уг систем бүхэлдээ нэрвэгдэж эхэллээ. Хүн амын өсөлт буурах хандлагатай (3-н 37) болсонд мэргэжлийн хүмүүс сэтгэл их түгших болов. Энэ хандлагыг зогсоох нь тийм ч хялбар биш. Монгол улсын боловсролын систем хямарч, хүн амын оюуны хоосрол эхлээд байна. Хүн амын залуу үеийн дотор архидалт, согтуурал ихэссээр байгаа нь нийгмийн хурц асуулын нэг болжээ. Хүн амын эрүүлийг хамгаалах ажил явц муутай байна. Харийн цагаачид нэмэгдсээр байгаа тухай хэвлэлд заримдаа цухас дурдаж байна. Нийгмийн хэв журам зөрчих, гэмт хэрэг үйлдэх явдал нийгмийн хурц асуудлын нэг болоод байна.

Дээр дурдсанаас үзэхэд Монгол улсын монгол үндэстний экологи хямралд ороод байна гэж хэлэх үндэстэй байна. Цааш яах вэ? Давын түрүүнд зохих судалгаа хийж, практик тодорхой арга хэмжээ авч, уг экологийг хямралаас гаргах нь чухал байна. Монгол үндэстэн эцсийн дүнд монгол хүмүүс мөн учир хүн судлалыг өргөн цартай болгомоор байна. Монголын хүн судлалын төв айгуулагдаж судалгаа хийж байгаа нь чухал байна. Сүүлийн жилд Оросод оросын түүхэн дэх хүний асуудлыг судлах «Одиссей» сэтгүүл (7) нийтлэгдэж байна. Монгол улсад өөрийн түүхэн дэх хүний асуудлыг судлаагүй учир манжийн колоничлолын үед монгол хүний зан төрхийг эвдсэнийг мэдэхгүй байна. Иймд Орос зэрэг орны туршлагыг анхаармаар байна.

Монгол үндэстний экологийн амин чухал бүрэлдэхүүн хэсэг нь соёлын экологи мөн. Үүнтэй холбогдуулан монголын соёлын экологи бас хямралд оржээ гэж нотлохгүйгээр хэлж болмоор байна. Сүүлийн жилд монголын соёл, түүний өвийн тухай ухагдахуун маш бүдэг тойм, зарим талаар гажуудуулсан байдалтай байгаа, тэр нь цааш гүнзгийрэх төлөвтэй байгаа нь соёлын экологийн хямралыг улам даамжруулах аюултай байна. Энэ нь хоёр шалтгаантай, үүнд: нэг нь ухагдахууныг тодорхойлох гэж бараг оролдоогүй, нөгөө нь улс төрийн тухайлсан тодорхой зорилготой холбоотой байх шиг байна.

Монгол үндэстний соёлын экологийг ярихын өмнө монгол үндэстний соёл, түүний өв гэдэг ухагдахууныг эрхбиш тодруулуштай.

Монгол улсын монголчууд, БНХАУ-ын өвөрлөгчид, Оросын Холбооны улсын буриадууд, халимагууд нь хэдэн зуун жилийн турш өөрсдийн нутагт тусгайдаа аж төрсөөр сүүлийн 100 шахам жил Монгол улс, Хятад улс, Орос улс гэх тусгаар тогтносон гурван улсын харьяат болсон учир тус тус үндэстэн болж, биеэ даасан соёлтой болжээ. Монгол улсын монголчууд, БНХАУ-ын өвөрлөгчид, Оросын холбооны улсын буриадууд, халимагуудын тус тусын соёл нь түүхийн тухайлсан тодорхой үед бүрэлдсэн ерөнхий шинжүүдээрээ монгол угсаатны соёлд хамаарагдана. Эдгээр соёл гурван улсын хооронд орчин үед тогтсон дэлгэр харилцааны хүрээнд харилцаж, нөлөөлөлцэж, харилцан баяжиж байх нь мэдээж.

Монгол улсын сүүлийн 100 шахам жилийн нийгэм-улс төр, эдийн засаг, соёлын хөгжлийн үр дүнд халх аялгууг суурь болгосон монголын шинэ бичгийн утга зохиолын нэгдмэл монгол хэл, орчин үеийн нэгдмэл соёл бүрэлдэн тогтжээ. Монгол үндэстний соёлын экологи нь чухам орчин үеийн монголын энэ соёлд холбогдоно. Монголын соёлын экологи нь соёлын өв, орчин үеийн соёлын зүйлс гэх хоёр дэд системтэй нэгэн бүхэл систем мөн. Орчин үеийн дэлхийн аль нэг биеэ даасан үндэстний соёлын экологи бүхэл систем мөний хувьд үндсэндээ адил.

Одоо дэлхийн бүх улс орчин үеийн техник гарвалын иргэншил дээр тулгуурласан буюу тулгуурлахыг эрмэлзсэн динамик хөгжилтэй нийгэм байгаа учир орчин үеийн соёлын зүйлс нь тэргүүлэх, харин өв нь дараалах функцтэй байна.

Хоёр дэд системийн шууд, урвуу эрэмбэ дараалсан холбоос, бүтцийг зохиомлоор өөрчлөх юм бол өөрчлөлтийн зүг рүү бүхэл систем аажимдаа хандан, хуучны уламжлал ноёрхвол орчин үеийн соёлын хөгжил хойш ухарна, эсхүл техник гарвалын зүйлс ноёрхвол соёлын үндэстний шинж алдагдана. Одоо Монголын соёлын өвийн асуудалд зарим талаар нэлээд ноцтой буруу хандлага гарч байх шиг санагдана. Тухайн түүхэн цаг үеийн үнэн байдлыг бодитойгоор цэгнэн, монголын соёлын өвийн асуудлыг шийдвэрлэх байх.

Монголын Юан улс (1260—1368)-ын үед монголын төр ёс, соёлын уламжлалыг нэлээд гажуудуулжээ. Манжийн колоничлогчид Монгол орныг 200 гаруй жил (1691—1911) ноёрхохдоо манжийн төрийн байгууллыг Монголд хүчээр байгуулах, шарын шашныг колоничлолоо зөвтгөх хүчтэй зэвсэг болгох, монгол угсаатны хувцас, заншил, зан үйлийг гажуудуулан завхруулах зэрэг туйлын хөнөөлтэй арга хэмжээг манжийн төрийн хүчээр хэрэгжүүлжээ. Монголын язгууртан нар манжийн хааны зарлигаар 1759 онд баталсан хуулнар монгол маягийн биш хувцас өмсч байв. Манжийн колоничлогчид Түвдэд дэлгэрсэн шарын шашиныг тэр хэлбэрээр нь Монголд нэвтрүүлэхдээ монголын хүн амын өсөлтийг зогсоон бууруулах, мөн хүн амаа тэжээхээр аж ахуйгаа эрхлэх боломжгүй болгох хэмжээгээр дэлгэрүүлжээ. БНХАУ-ын судлаачид энэ талаар бичихдээ: «1570—1582 оны үед баруун, зүүн монголчууд 1090000 байжээ. Манж Чин улсын үед (1644—1922) шарын шашин дэлгэрсэн нь монголын хүн амын өсөлтөнд нөлөөлөв. Манжийн Тэнгэрийн Тэтгэсэн хааны (1736—1795) үед монголын хүн ам хорогдон 1030000 болжээ. Түүнээс хойших 100 гаруй жилийн дотор 1030000-нас 829000 болон хорогдсон» гэжээ. (6-н 51). Энэ 100 гаруй жилийн дотор 201000 хүнээр буюу 19,5%-нар хорогджээ. Манжийн колоничлолын үед монголын хүн ам 1090000 байснаа 261000

хүнээр буюу 23,9%-иар хорогдон 829000 болсон байна. Шарын шашныг монголын хүн ам аажимдаа мөхөх хэмжээнд хүртэл хэтрүүлэн дэлгэрүүлсэн ажиллагаатай холбогдон шашны дурсгалт зүйлийн ихэнх нь монгол угсаатны соёлын өв биш, ердөө түүхийн дурсгалт зүйл болсон юм. Хятад хүмүүс Монголд байсан 700 гаруй сүм хийдийн дийлэнхийг доторх бурхан зэрэг хэрэглэлтэй нь хамт барьж бүтээжээ. Тэдгээр нь Монгол оронд Монголын ард түмний хөрөнгөөр монгол хүмүүст зориулан бүтээгдсэний хувьд монголын түүхийн дурсгал болно. Сүүлийн үе хүртэл монголчууд үхсэн хүний цогцсыг хээр ил оршуулдаг байсан нь угтаа Түвдэд үхэгсдийн цогцсыг хэсэгчлэн махчин шувуудад шидэж өх ёсыг монголын байдалд бага сага тохируулсан хэрэг юм. Монголчууын заншил, зан үйлийг манжийн колоничлолын үед гажуудуулсан иймэрхүү олон баримтыг дурдаж болно.

Түүхийн сурвалж бичгийн хөдөлбөргүй мэдээнээс үзэхэд бурхны шашин 2000 гаруй жилийн өмнө Хүннү улсын үед Монголд нэвтрэн төр ёсны уламжлалын үзэл суртлын үндэс болж эхлээд, Монгол-Нирун улсын (330 орчим-555) үед төрийн шашин болж байв. Үүнээс үзэхэд бурхны шашин Түвдээс өмнө Монголд нэвтрэн дэлгэрч, төрийн шашин болжээ. Монголчууд Манжид дагаар орохоос өмнө бурхны шашны гол зохиол болох 108 боть ганжуур, 225 боть данжуурыг монголоор орчуулаад ихэнхийг модон бараар хэвлэжээ. Иймд бурхны шашныг түвд хэлээр явуулах түүхэн үндэс огт байхгүй. Түвд хэл бол монгол, хятад, япон хэлний адил бурхны номын орчуулгын хэл мөн. Бурхны номын жинхэнэ хэл бол пали, санскрит хэл юм. Ингэхлээр Монголд бурхны шашин худам монгол бичгийн хэлээр эсхүл пали, санскрит хэлээр явагдах нь зүй ёсны хэрэг болно. Сүүлийн үед Монгол улсад бурхны шашны жижиг судрыг нэлээдийг хэвлэсэн нь нэг ёсны завхруулга гэж хэлж болмоор байна. Бурхны шашины ном зохиол эх бичгийн хувьд зохих баталгаатай байх ёстой байх. Жишээлбэл, 1871 онд Бирмийн Мандалай хотод бурхны ном мэддэг 2400 лам бурхны шашны гурван сав номын янз бүрийн эх, орчуулгыг нягтлаад, жинхэнэ мадаггүй эхийг тусгайлан бэлтгэсэн 729 гантисамбар дээр сийлэн тус бүрд нь жижиг суврага бариад хадгалах болжээ. (4-н 48)

Монгол улсын монгол үндэстэн худам монгол бичгийн хэлний зэрэгцээгээр ХХ зуунд орчин үеийн кирил монгол бичгийн хэлтэй болсон нь үндэстний экологийн хувьд асар их ач холбогдолтой амжилт болжээ. Сүүлийн хэдэн арван жилд худам монгол бичгийн хэрэгцээг эрс багасгасан гажуудлыг одоо засахыг оролдож байгаа нь цаг үеэ олсон чухал арга хэмжээ мөн. Харин орчин үеийн кирил монгол бичгийн хэлийг хэрэглэхгүй болгон худам монгол бичгийн хэлийг дангаар ноёрхуулах юм бол яваандаа экологийн хувьд асар их хөнөөлтэй ажил болно. Монгол үндэстнийг орчин үеийн нэгдмэл утга зохиолын хэлгүй болгох нь урьдчилан тооцохын аргагүй сөрөг үр дагавар бий болгох нь мэдээж.

Монгол бичгийн утга зохиолын хоёр хэлийг зохистой хэлбэрээр хослуулан хэрэглэх саналаа академич А. Лувсандэндэв, (Бодлын солилцоол, 1991. 8. 3. № 3), доктор Ш. Гаадамба (Улаанбаатар, 1993 3. 19. № 044) зэрэг монгол хэл, утга зохиолын том мэргэжилтэн сонин хэвлэлээр тавьсныг үзэхэд тэдгээр нь монголын соёлын экологийн хямралаас сэрэмжилсэн учир хэрэгжүүлүүштэй чухал санал байна. Монголын соёлын экологид шинжлэх ухааны үүднээс нарийн хандах ёстой байх. Сэтгэлийн хөөрөл, улстөрийн эчнээ зорилгоос хандвал хөнөөлтэй болно.

Монгол улсын үндэсний эрх ашиг бол монгол үндэстний экологийн амин сүнс болсон маш эгзэгтэй нарийн асуудал учир цогцолбор судалж, цогцолбор арга хэмжээ боловсруулан хэрэгжүүлэхийг шаардаж байна. Орчин үе, ирээдүй бол зөвхөн Монгол улсын хувьд биш, бусад улсын хувьд, ер нь хүн төрөлхтний хувьд маш эгзэгтэй байгааг орчин үеийн дэлхийн нийгмийн нэрт сэтгэгчдийн нэг О. Тоффлер «Ирээдүйн дайрлага», «Гуравдугаар долгион», «Хүчний шилжилт» гэх дэлхийн 50 гаруй оронд сая сая хувиар хэвлэгдсэн гурвал зохиолдоогийн хэлээр хүний ой тойнд орохоор харуулжээ. О. Тоффлер «Хүчний амьдралын бодит байдалд тулгуурлан онолын сэтгэхүйн үүднээс энгийн хэлээр хүний ой тойнд орохоор харуулжээ. О. Тоффлер «Хүчний шилжилт» зохиолдоо зах зээлийн харилцааны эерэг, сөрөг тал, орчин үед хүчний шилжилт хувьсгал болж байгааг (11-н 3—66) дурдаад XXI зуунд хүн төрөлхтөн ардчилалаа өөрчлөн байгуулж чадахгүй болбол ирээдүйд шинэ харанхуй үе ноёрхож болох аюулаас урьдчилан сэрэмжлүүлж байна (11-н 364—379). О. Тоффлер орчин үед шашны фундаментализм (давамгайлах үзэл) олон оронд дэлгэрэх байдалтай байгааг «Хутагтын хэнээрхэл» гэх гарчиг тавиад дурдаж байна. (11-н 364—368) Тэр цааш нь «Бөмбөрцгийн гладиатор» гэдэг гарчиг (11-н 450—460) тавиад Аятол Хомейни мэтийн шашны зүтгэлтэн, хар тамхины мафи, олон улсын шинэ байгууллага зэрэг бий болж байгаа тухай өгүүлжээ.

Монгол улсад шарын шашин манжийн колоничлолын үеийн хэлбэрээрээ их дэлгэрэх хандлагатай байгаа нь сөрөг дагаваргүй байх болно гэх баталгаа байхгүй.

3. Монгол улсын эдийн засгийн тусгаар тогтнолыг хамгаалах, бэхжүүлэх нь орчин үеийн зах зээлийн нөхцөлд нээлттэй эдийн засгийн бодлого явуулж байгаа үед хэрэгжихэд маш төвөгтэй мэт санагдавч үнэн хэрэг дээрээ харьцангуй хялбар асуудал юм. Өөрийн хүчинд тулгуурлах бодлогыг төрийн нарийн зохицуулах, зохион байгуулах үйл ажиллагаатай зөв хослуулах юм бол тус улсын эдийн засгийн тусгаар тогтнолыг хамгаалан, бэхжүүлж чадна. Гол нь төрийн нарийн зохицуулах, зохион байгуулах механизмыг бий болгох нь чухал байна.

АНУ мэтийн орчин үеийн өндөр хөгжилтэй орны нэрт эдийн засагчдын сүүлийн үеийн зарим бүтээлийг (5, 8, 12, 13, 14) сонирхон үзэхэд зах зээлийн эдийн засгийн харилцаа нэг талаар ямар нэг бэлэн загвар биш, харин дэлхийн олон эдийн засагчдын янз янзын онол, үзэлд тулгуурласан улс тус бүрийн өвөрмөц онцлогт нийцсэн харилцаа, нөгөө талаар зах зээлд шилжинэ гэдгийг эцсийн зорилго болгон амаар тунхагламагцаа урьд бүтээсэн бэлэн аж ахуй, соёл зэргээ яаравчлан бусниулах ажил биш болох нь эргэлзээгүй тодорхой байна. Дэлхийн эдийн засгийн ухааны том бүтээлүүдэд эдийн засгийн үр ашгийг маш чухалчлан тавьж байна (8-н 15; 12-н 188; 13-н 177, 14-н 43—43). Дэлхийн нэрт эдийн засагчид «Хүн капиталд хөрөнгө оруулах» асуудлыг тавьж байна (14-н 801—802). Манай улсад хүн капитал маань сэтгэл түгших хэмжээнд архичин болсон тухай хэвлэлд их бичих боллоо. Иймд манай хүн амын дотор архидалт их дэлгэрч байгаагийн эсрэг тэмцэх нь Монгол улсын үндэсний эрх ашгийг хамгаалах асуудал болоод байна.

4. Монгол орны байгалийн унаган төрх байдлыг хэвээр хадгалах нь Монгол улсын үндэсний эрх ашгийн нэг гол зүйл мөнөөр барахгүй Монгол улс хүн төрөлхтний өмнө хүлээсэн хариуцлагын асуудал мөн. «Бүгд Найрамдах Монгол Ард Улс. Үндэсний атлас» номд Монгол орны байгалийн унаган төрх өвөрмөц байдал, баялгийг олон талаас

нь тодорхой харуулснаас цөөвтөр жишээ дурдая. «Тус орон нэлээд өндөрлөг газарт байрласан нь түүний гол онцлог юм. Тухайлбал бүх нутгийн 80 орчим хувь нь далайн түвшнээс дээш 1000 гаруй метрт оршино» гэж (1-н 25) Монгол орны нэг өвөрмөц талыг уг Атласт цохон дурджээ.

Монгол улс ургамал, амьтны аймгийн талаар бас өвөрмөц сонин байна. «Монгол орон Палеарктикийн салбар болох эрс тэс эх газрын шинж бүхий Дорнод Сибирь-Төв Азийн нутгийн төв хэсэгт нь байрладаг учир ургамлын хувьд хосгүй өвөрмөц байдалтай» байна. (1-н 71), «Монгол орны амьтны аймаг баян, төрөл зүйл олонтой. Тус оронд 630 орчим зүйл сээр нуруутан амьтан байдгаас гадна элдэв бүлэг сээр нуруугүй амьтан ч их бий. Монгол оронд 130 орчим зүйл хөхтөн бий... Монгол орон 17 багт хамаарах 400 гаруй зүйл шувуудтайн 300 гаруй нь өндөглөн зусдаг шувуу юм... Монгол оронд 30 орчим зүйл хоёр нутагтан, мөлхөгчид байдаг... Монгол орны нуур голуудад 12 овогт хамаарах 60 гаруй зүйл загас, загас хэлбэртэн амьдардаг» байна. (1-н 77). Ёстой амьтны хүрээлэн мөн байгаа биз. Монгол улс «гадаргын болон газрын доорхи усны харьцангуй их нөөцтэй орон юм» байна (1-н 60). Манай гариг дээр амьдрал усны мөчлөгийн хүчинд байдаг (10-н 188) учир ус бол үнэхээр чухал баялаг мөн.

Дэлхийд экологийн хямрал заналхийлж байна. 1990—1991 оны судалгаагаар хөгжиж байгаа зарим оронд газрын хөрсний эвдрэл, газрын доройтлын бусад хэлбэр үндэсний нийт бүтээгдэхүүнийг 5—10% хүртэл бууруулж байна (10-н 80). Ингэхлээр Монгол улс байгалиа хамгаалах нь үнэн чанартаа үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээ нэмэгдүүлж байгаа хэрэг болно.

Дэлхий, түүний байгаль, баялаг хэмжээтэй. Дэлхийн газрын талбай барагцаалбал 115 тэрбум гектар байгаагаас хуурай газрын мөс, мөн 5000-аас дээших өндөр газрын талбайг хасвал эх газрын талбай нь 111,5 тэрбум гектар болно. Хүмүүс чухам энэ талбай дээр амьдарч, хүнсний зүйл бүтээж, байгалийн нөөцийг сэргээн байж чадахаар төлөвтэй байна. Газрын нийт талбайн зөвхөн 25% орчим нь ерөнхийдөө тариалж болох газар байна (10-н 80).

Монгол улс өөрийн орны байгаль, түүний баялгийг хамгаалж, хадгалж чадах юм бол тэр нь хоёр төрлийн шавхагдашгүй баялгийн эх үүсвэр болж болно. Үүнд: нэгд, унаган төрхөөрөө байгалиа гадаадын тойрон аялагчдад зөвхөн харуулаад л байхад мөнгө олоод л байх болно; хоёрт, газрын хөрсний дээрх, доорхи баялгаа зөв зохистой ашиглаж чадвал монголын ард түмнийг дэлхийн тэргүүний хөгжилтэй орны хүн амын дээд түвшний амьдралтай болгож чадна. Ёстой эзэн хичээвэл заяа хичээнэ.

Хүний сэтгэхүйн хэвшсэн загварыг эвдэхгүйгээр ямар нэг ажлыг олигтой үр дүнтэй гүйцэтгэж чаддаггүй онцлогийг харгалзах нь чухал байна. Иймд экологи эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэхгүйгээр Монгол орны байгалийн унаган төрх байдлыг хамгаалан хадгалж чадахгүй. Байгалийн унаган төрх байдлыг хэвээр хадгалах нь газрын төрхийг (ландшафтыг) хэвээр байлгахаас эхлэх байх. Ингэхлээр экологи эдийн засаг нь байгаль, газрын төрх байдалд эдийн засаг, аж ахуйн үйл ажиллагаагаа захируулна гэсэн хэрэг мөн.

Монгол улс уудам нутгийнхаа байгалийн унаган төрх байдлыг ерөнхийд нь хэвээр хадгалж үлдсэн, тусгаар тогтносон улсын хувьд дэлхийд онцгой байр суурь эзэлж байна. «Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Үндэсний атлас»-т тодорхойлсноор Монгол улс байгалийн өвөрмөц онцлогтой бөгөөд бүхэл нутгаараа манай дэлхий гаригийн

нэгэн сонин дархан газар шиг байгаа юм. Одоо Монгол улсын нутаг чухам иймэрхүү байгаа учир 1992 оны 6-р сард Бразилийн Рио-де-Жанейро хотод хуралдсан Байгаль орчин, хөгжлийн асуудлаархи НҮБ-ийн бага хурал «Монгол орны нутаг дэвсгэрийг олон улсын онцгой хамгаалалттай дэлхийн шим мандлын тусгай бүс газар» болгох саналыг Дэлхийн олон улсад хандсан тайлбарлах бичигтээ дурджээ. Энэ бол Монгол улсын нутгийн байгалийн унаган төрх байдлыг хэвээр хадгалах явдлыг НҮБ маш чухалчлан үзэж байгаагийн тод гэрч мөн. Энэ бол хүн төрөлхтний өмнө Монгол улс хүлээх хариуцлага болж байна. Одоо энэ хариуцлагаа ухамсарлан биелүүлэх цаг болжээ.

5. Монголын ард түмний аж амьдрал, соёлын түвшинг орчин үеийн тэргүүний хөгжилтэй орны хүмүүсийн тэр хэмжээнд хүргэх нь монгол улсын үндэсний эрх ашгийн чухал зорилго мөн. Орчин үеийн зах зээлийн харилцаа хүмүүсийн идэвх өрнүүлэх талаар хуучин социалист системээс зүйрлэшгүй давуу талтай боловч «дийлсэн нь дийлдсэнээ» гэх маш аймшигт үр дагавартайг мартаж огтхон ч болмооргүй. Зах зээлийн харилцааны сөрөг талд давын түрүүнд хөдөлмөрчин олон түмэн нэрвэгдэх нь мэдээж. Иймд зах зээлийн харилцааны эерэг талыг дэмжих, сөрөгийг нь хазаарлах найдвартай механизмыг бий болгох ажил нэгэн зэрэг явагдаж чадвал ард түмний аж амьдралын түвшинг байнга дээшлүүлсээр байх боломжтой юм.

6. Монголын нүүдлийн сонгодог мал аж ахуй. Монгол орны нэг өвөрмөц баялаг мөн. Академич М. Төмөржав «Бэлчээрийн монгол мал» зохиолдоо монгол малын талаар бичихдээ: «Төв Азийн өвөрмөц экологийн нөхцөлд байгалийн уртын шалгарал, малчин түмний маань олон зууны мал маллагаанд шингэсэн ардын селекцийн нөлөөлөлцлийн үрдүнд биологи, удамшил, экологийн онцгой шинжит эрхэм генофонд шингэмэл нутгийн монгол мал үүсэн бий болжээ» гэжээ (2-н 3--4). Иймд монгол мал Монгол улсын үндэсний баялаг мөнөөр барахгүй хүн төрөлхтний баялаг мөн гэж үзэж болно. Монгол улсын их хурал 1993 онд «Малын удмын сан, эрүүл мэндийн тухай хууль» баталсан нь ёстой цаг үеэ олсон чухал арга хэмжээ мөн гэж үзүүштэй.

Зургаан махбодьтой, «Монгол улсын үндэсний эрх ашиг» гэх нэгэн бүхэл систем буюу организм ийм байна. Монгол улсын гадаад, дотоод бодлого, түүнийг хэрэгжүүлэх бүхий л үйл ажиллагаа нь энэ үндэсний эрх ашгаар тодорхойлогдох нь мэдээж.

Дэлхий дахины байдал маш ээдрээтэй, хямралтай байна. Одоо Монгол улс улстөр, нийгэм, эдийн засаг, соёл, ёс суртахууны гүнзгий хямралд ороод байна. Ийм үед Монгол улсын үндэсний эрх ашгийг хамгаалан хэрэгжүүлэх төрийн бодлого ямар байх вэ? гэх асуулт тавигдаж байна. Олон улсын харилцаа судлаач Г. Төмөрчулуун «Ардын эрх» сонины (1992. 12. 16, № 189) сурвалжлагчтай ярилцахдаа: «Миний бодоход Монгол улс прагматик бодлого явуулах нь манай онцлог, олон улсын харилцааны шилжилтийн энэ үед илүү нийцнэ» гэсэн нь анхаарууштай үг байна. Бүтээлч, хөдөлмөрч сэхээтний эрүүл ухаан дээр тулгуурласан бодлого хэрэг болно.

НОМ ЗҮЙ

1. Бүгд Найрамдах Монгол Ард Улс, Үндэсний атлас, УБ, 1990, Москва.
2. Т. Төмөржав, Бэлчээрийн монгол мал, Улсын хэвлэлийн газар, Улаанбаатар, 1989.
3. Х. Цэдэнсодном, Монгол улсын хүн амын өнөөгийн ба хэтийн зарим асуудал—«Зүүн хойт Ази судлал» № 2 (2), 34—37-р тал.
4. А. Н. Кочетов, Буддизм, Издательство «Наука» Москва, 1965.

Кеэмпбелл Р. Макконнелл, Стэнли Л. Брю. Экономикс (Принципы, проблемы и политика). Том I. Москва, Издательство «Республика». 1992.

6. Нэй мэngu да цыдянь (Өвөр Монтолын том толь). Нэй мэngu жэньминь чубаньшэ. Хөх хот. 1991. (Хятадаар)

7. Одиссей. Москва. «Наука». 9 1990.

8. П. Самуэльсон. Экономика. Том. I. Москва, МГП «Алгон», ВНИИСИ. 1992.

9. Френсис Фукуяма. Неясность «Национального» интереса, «Независимая газета», 16, 10. 1992. № 200 (371)

10. An Agenda of Science for Environment and Development into 21st Century (Based on a Conference held in Vienna, Austria in November 1991). Cambridge University Press. 1992.

11. Alvin Toffler. Powershift. Bantam Books, New York, 1991.

12. C. Pass, B. Lowes, L. Davies, S. J. Kronish. The Harper Collins dictionary of economics. Harper Perennial, New York. 1991.

13. Stanley Fischer, Rudiger Dornbusch, Richard Schmalensee. Economics. Second Edition. McGraw-Hill book Company. New York. 1988.

14. William J. Baumol, Alan S. Beinder, Economics, Principles and Policy. Fourth Edition. Harcourt Brace Javanovich, Publishers. New York. 1988.